



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Алтанширээ сумын ТТЗ-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/8/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020

Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Утас: 70523020

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ДГА	Дорноговь аймаг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТӨҮГ	Төрийн өмчит үйлчилгээний газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮОМШӨ даатгал	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	9
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	9
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.11.	Шилэн дансны мэдээлэл	11
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	12
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	14
3.1	Тухайн байгууллага салбартай холбоотой хууль эрх зүйн орчин	14
3.1.1	Илрүүлэлт:	14
3.1.2	Эрсдэл:.....	14
3.1.3	Өгсөн зөвлөмж:	14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	16
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	18
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	21
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	24
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	25
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	27

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.03.20 № 1-6/337

танай _____-ны № _____-т

АЛТАНШИРЭЭ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Л.ЦЭЦЭГДАРЬ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсвийн шууд захирагч 6 байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөрчилгүй, 2 хязгаарлалттай, 1 санал дүгнэлт өгөхөөс татгалзсан санал дүгнэлт авсан байна. 2 байгууллага түүврийн аудитад хамрагдсан.

Сумын Засаг даргын Тамгын газар 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь цаг хугацааны хязгаарлалтад оруулж санал дүгнэлт өгөхөөс татгалзсан. Засаг даргын Тамгын газрын 2018 оны төсвийн нийт гүйцэтгэл 239.3 сая төгрөг буюу Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн нийт гүйцэтгэл /1,218.6 сая төгрөг/-ийн 19.6 хувийг эзэлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлалттай санал дүгнэлт авсан.

Эрүүл мэндийн төв 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь цаг хугацааны хязгаарлалтад оруулж хязгаарлалттай санал дүгнэлт авсан байна.

Тус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд материаллаг байдлын түвшинг 12.1 сая төгрөгөөр тогтоосон. Төсвийн шууд захирагчдын тайланд илэрсэн зөрчил нь 101.2 сая төгрөг буюу бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 8 дахин давсан байна.

Үүрэг, хариуцлага

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Алтанширээ сумын ТТЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Алтанширээ сумын Засаг даргад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алтанширээ сумын ТТЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанширээ сумын ТТЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.05-наас 2019.03.15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Алтанширээ сумын ТТЗ 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2019.03.04-ний өдрийн 1/66 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Алтанширээ сумын ТТЗ-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Иргэдэд төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, оновчтой бодлого зохицуулалтаар хангахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Алтанширээ сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага

Алтанширээ сумын ТТЗ-ийн удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 6 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 6 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Алтанширээ сумын ТТЗ-ийн эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	4	2	-	-	-
	Дүн	4	2	-	-	-

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Алтанширээ сумын ТТЗ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой “нийцсэн” байна.

Алтанширээ сумын ТТЗ-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд “эрсдэлгүй” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах “шаардлагагүй” гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Алтанширээ сумын ТТЗ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Э-тайлан” онлайн програм хангамж ашигладаг байна.

Алтанширээ сумын ТТЗ-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар Алтанширээ сумын 6 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийжээ. Аудитаар нийт 70,570.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 70,570.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллажээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Алтанширээ сумын ТТЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардлын 1* хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийгдсэнтэй холбоотой юм.

Алтанширээ сумын ТТЗ 2018 оны Нийт зардал 1,218,605.1 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 12,186.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулав байна.

Алтанширээ сумын ТТЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 101,210.9 мянга, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 42,345.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

(Төсвийн өмнөх шатлалд хийсэн аудитаар илрүүлсэн материаллаг хэмжээний анхаарал татахуйц алдаа, зөрчилтэй асуудлыг тоймлон энд оруулав)

Асуудал 1: Балансын данстай холбоотой асуудал Алтанширээ сумын Хүүхдийн цэцэрлэг

Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл үнийн дүнгээр тайлагнаагүй нийт дүнгээр гаргасан байна. /21,711.1 мянган төгрөг/

Шийдэл: Зөвлөмж өгсөн.

/Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан заавар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах, бараа материалд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх/

Асуудал 2: Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургууль

Тайлант онд түлш халаалтын зардал 28,634.5 мянган төгрөг, хоол хүнс 18,372.3 мянган төгрөг, багаж техник хэрэгсэл 13,579.9 мянган төгрөг, урсгал засвар 60,600.0 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн ба үүнээс урсгал засварын зардалд зарцуулсан 50,088.5 мянган төгрөгийн худалдан авалтыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгэж тайлагнасан ба үлдэх 71,098.2 мянган төгрөгийн худалдан авалтыг холбогдох хуулийн дагуу хийж гүйцэтгээгүй байна.

Шийдэл: Албан шаардлага өгсөн.

/Тайлант оны худалдан авалтыг хэрэгжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах/

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	42,000.0	Сумын ИТХ-аас төсөл сонгон шалгаруулалтын товын тогтоол гараагүй байхад төсөл сонгон шалгаруулж, зээл олголтыг хийсэн байна.
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	-
3	Албан шаардлага өгсөн	1	345.0	Нөхөн сэргээлтийн сангийн данснаас золбин нохой устгах ажилд 345.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	-
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	-
	Дүн	2	42,345.0	-

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Илрүүлэлт. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Нөхөн сэргээлтийн сангаас 2018 онд сумын Засаг даргын захирамжаар золбин нохой устгах ажилд 345.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 5.5 дахь заалт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэл. Хөрөнгө зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх, холбогдох журам мөрдөгдөхгүй байх.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Алтанширээ сумын ТТЗ-ийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 8 хөтөлбөр, 27 арга хэмжээнд зориулан 1,248,707.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 73,954.5 мянган төгрөг буюу 103.3 хувь, зардлын нийт гүйцэтгэл 1,218,605.1 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байна.

Төсвийн зардлын төлөвлөгөөний биелэлтийг харъяа байгууллагаар нь авч үзвэл: Иргэдийн Төлөөлөгчдийн хурал зардлын нийт гүйцэтгэл 43,320.1 мянган төгрөг буюу 99.8 хувь, Засаг даргын Тамгын газар зардлын нийт гүйцэтгэл 239,373.6 мянган төгрөг буюу 99.8 хувь, Ерөнхий боловсролын сургууль зардлын нийт гүйцэтгэл 394,517.1 мянган төгрөг буюу 99.6 хувь, Хүүхдийн цэцэрлэг зардлын нийт гүйцэтгэл 120,005.6 мянган төгрөг буюу 98.2 хувь /хоол хүнсний зардал хэмнэснээс шалтгаалжээ/, Соёлын төвийн зардлын нийт гүйцэтгэл 69,081.5 мянган төгрөг 99.4 хувь, Эрүүл мэндийн төв зардлын нийт гүйцэтгэл 235,435.1 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь төсөвт зардлыг батлагдсан хэмжээнд зарцуулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Алтанширээ сумын ТТЗ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Алтанширээ сумын ТТЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 50.2 хувь буюу 72,087.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 49.8 хувь буюу 71,469.0 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	2	42,345.0	-	-	2	42,345.0	-	-
2	ТШЗ	8	101,211.6	-	-	8	101,211.6	-	-
	Дүн	10	143,556.6	-	-	10	143,556.6	-	-

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(Мянган төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	8	101,211.6	-	-	2	71,742.6	6	29,469.0	-	-	-	-
2	ТШЗ	2	42,345.0	-	-	1	345.0	1	42,000.0	-	-	-	-
	Дүн	10	143,556.6	-	-	3	72,087.6	7	71,469.0	-	-	-	-

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Алтанширээ сумын ТТЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Алтанширээ сумын ТТЗ-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Алтанширээ сумын ТТЗ-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	ТШЗ	1	2	-	1	4
	Дүн	1	2	-	1	4

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Алтанширээ сумын ТТЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.1.1 Илрүүлэлт Сумын ИТХ-аас төсөл сонгон шалгаруулалтын товын тогтоол гараагүй байхад төсөл сонгон шалгаруулж, зээл олголтыг хийсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.11 дэх заалт “Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20-с доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухайн сумын ИТХ тогтооно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл. Журам мөрдөгдөхгүй байх, ашиг сонирхлын зөрчил үүсэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж. Сангийн хөрөнгийн 20-с доошгүй хувь бүрдэж, сумын ИТХ-аас төсөл сонгон шалгаруулалтын товын тогтоол гарсан үед төсөл сонгон шалгаруулж, зээл олголт хийх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	420,224,016.89	365,640,701.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	42,545,892.14	59,831,673.14
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	42,545,892.14	59,831,673.14
31210	Төгрөг	42,545,892.14	59,831,673.14
31211	Төрийн сангийн харилцах	42,545,892.14	59,831,673.14
33	АВЛАГА	150,633,751.40	139,213,095.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,086,000.00	100,500.00
33500	Бусад авлага	14,948,633.00	12,238,478.00
33510	Байгууллагаас авах авлага	13,760,633.00	12,049,478.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,188,000.00	189,000.00
33600	Зээлийн авлага	134,599,118.40	126,874,117.60
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	134,599,118.40	126,874,117.60
33612	Хувь хүмүүст олгосон зээл	134,599,118.40	126,874,117.60
35	БАРАА МАТЕРИАЛ	227,044,373.35	166,595,932.35
35100	Түүхий эд материал	34,972,182.00	44,287,182.00
35110	Тусгай зориулалттай материал	34,972,182.00	44,287,182.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,200.00	4,200.00
35400	Хангамжийн материал	192,064,991.35	122,304,550.35
35410	Бичиг хэргийн материал	680,660.00	1,131,820.00
35420	Аж ахуйн материал	151,900,040.35	78,529,554.35
35440	Түлш, шатах тослох материал	17,620,250.00	17,944,000.00
35460	Хүнсний материал	12,116,545.00	12,275,280.00
35470	Бусад хангамжийн материал	9,747,496.00	12,423,896.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,954,496,499.49	3,260,867,090.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,954,496,499.49	3,260,867,090.19
39200	Биет хөрөнгө	2,948,459,081.43	3,152,790,605.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,911,445,627.00	2,361,289,450.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,797,688,042.51	-83,293,685.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	143,448,790.00	215,738,790.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-88,797,976.02	-88,163,882.13
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	288,529,459.91	359,801,157.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-156,912,325.64	-210,220,944.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	190,070,044.39	161,566,806.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	-136,645,379.04	-124,839,040.51
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,794,450.00	1,794,450.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	824,006,259.60	864,202,487.29
39215	Хуримтлагдсан элэгдэл	-241,792,549.83	-317,190,706.80
39217	Ном	11,000,723.57	12,105,723.57
39300	Биет бус хөрөнгө	6,037,418.06	108,076,484.66
39301	Програм хангамж	2,054,500.00	2,054,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,816,166.80	-1,878,500.20
39303	Бусад биет бус хөрөнгө	6,359,084.86	107,900,484.86
39304	Хуримтлагдсан элэгдэл	-560,000.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,374,720,516.38	3,626,507,791.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,131,859.00	2,030,703.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,131,859.00	2,030,703.00
41300	Өглөг	9,131,859.00	2,030,703.00
